

## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

#### ХЭНТИЙ АЙМГИЙН БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2026/181/НА-СТА-ТШЗ

---

Чингис хот 2026 он  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

**Тэргүүлэх аудитор:** Ж.Ганбаатар  
Утас: 70562112  
Цахим хаяг: [ganbaatarj@audit.gov.mn](mailto:ganbaatarj@audit.gov.mn)

**Аудитын менежер:** Д.Оюунтуяа  
Утас: 99775390  
Цахим хаяг: [oyuntuyad@audit.gov.mn](mailto:oyuntuyad@audit.gov.mn)

**Аудитор:** Х.Еркегүл  
Утас: 99040705  
Цахим хаяг: [erkegulkh@audit.gov.mn](mailto:erkegulkh@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn) хаягаар авна уу

---

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	14

---

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОХНСАХ	Байгал орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

᠒᠐᠒᠖.᠐᠒.᠒᠔ № ᠒᠕᠖  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТШИРЭЭТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.БҮДХАНД ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Олон нийтийн цагдаагийн ажилтанд үндсэн үйл ажиллагааны бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 5.0 сая төгрөгийн урамшуулал, засаг даргын орлогчоор ажиллаж байгаад сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн иргэнд 11.2 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгож, нийт 16.2 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг үндэслэлгүй зарцуулсан. байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 47.9 сая төгрөгийн урьдчилгаа олгосон 4 арга хэмжээний гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй, тухайн арга хэмжээг тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөж, үлдэгдэл санхүүжилтийг сумын ИТХ-аар батлуулсан боловч хэрэгжээгүй, гүйцэтгэлд хяналт тавиагүй, арга хэмжээ авч ажиллаагүй, санхүүжилтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж баримтжуулаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд орон нутгийн төсвөөс 2,849.8 сая төгрөгийн санхүүжилт авч 80 хувь буюу 2,266.0 сая төгрөгийг зарцуулж, 583.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд 65.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 55.2 сая төгрөгийг зарцуулж, 9.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Сумын ОНХО-аар хэрэгжих 10 төсөл арга хэмжээнд 585.5 сая төгрөгийн төсөв баталж 368.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжиж, Төсвийн санхүүжилтийн эрх нээгдээгүй нөхцөл байдалтай холбоотой БОХНСАХЗ болон бусад хөрөнгийн зардалд төлөвлөсөн төсөл арга хэмжээний санхүүжилт хийгдээгүйгээс шалтгаалан урьдчилж төлсөн зардал 198.0 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хэнтий аймгийн Онцгой байдлын газар, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран хэрэгжүүлсэн “Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх” чиглэлээр Пин төслөөс 33.0 сая төгрөгийн түймрийн багаж хэрэгсэл авсан. Тайланд онд орон нутгийн хөгжлийн сангаас 277.9 сая төгрөг, аймгийн БОАЖГ-ын БОХНСАХЗ-аас хийгдсэн 15.0 сая төгрөг, үлдэх өртгөө бүрэн нөхөж элэгдлийн хугацаа дууссан боловч ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн өртгийг шинэчлэн тогтоож 12.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 138,4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 85.4 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, олон нийтийн цагдаагийн ажилтан томилж үндсэн үйл ажиллагааны зардлаас 5.0 сая төгрөгийн цалин олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан, тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж сумын ИТХ-аар батлуулсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан ч гэрээнд заасан хугацаанд хүлээж авч гүйцэтгэлийг дүгнээгүй, олгосон урьдчилгаа, үлдэгдэл санхүүжилтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 47.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 105 зорилтын хүрээнд 238 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 88 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага** Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээш түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>261,100,684.63</b>	<b>528,570,667.46</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
33	<b>АВЛАГА</b>	<b>57,679,811.67</b>	<b>57,471,151.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4.67	194,875.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	8,473,046.00
335	<b>Бусад авлага</b>	57,679,807.00	48,803,230.00
3351	Байгууллагаас авах авлага	57,679,807.00	48,258,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	545,230.00
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>95,615,942.00</b>	<b>281,289,685.50</b>
34600	Урьдчилж гарсан зардал	95,615,942.00	281,289,685.50
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>99,274,930.96</b>	<b>171,023,830.96</b>
354	<b>Хангамжийн материал</b>	70,674,930.96	114,873,830.96
35410	Бичиг хэргийн материал	2,617,000.72	2,651,600.72
35420	Аж ахуйн материал	67,897,930.24	112,222,230.24
35440	Түлш, шатах тослох материал	160,000.00	-
35600	Мал амьтад	28,600,000.00	56,150,000.00
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>8,530,000.00</b>	<b>18,786,000.00</b>
36300	Тэжээлийн нөөц	8,530,000.00	18,786,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,987,109,372.83</b>	<b>3,247,374,602.24</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,987,109,372.83</b>	<b>3,247,374,602.24</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	2,715,654,572.83	2,975,919,802.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,964,632,192.00	2,064,632,192.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(418,030,390.54)	(517,297,556.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	287,465,069.17	462,465,069.17
39204	Хуримтлагдсан элэгдэл	(71,560,839.04)	(132,297,150.71)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	179,362,659.17	212,031,977.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,518,543.42)	(94,161,001.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,770,400.00	89,017,750.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,674,434.26)	(44,569,437.52)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,081,226,257.00	1,324,152,656.76
39210	Хуримтлагдсан элэгдэл	(284,189,097.25)	(398,225,996.78)
39217	Ном	10,171,300.00	10,171,300.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	271,454,800.00	271,454,800.00
39301	Програм хангамж	1,300,000.00	1,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,300,000.00)	(1,300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	271,454,800.00	271,454,800.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,248,210,057.46</b>	<b>3,775,945,269.70</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,453,839.70</b>	<b>5,870,925.36</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,453,839.70	5,870,925.36
413	<b>Өглөг</b>	5,453,839.70	5,870,925.36
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	5,623,425.36
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,453,839.70	247,500.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,242,756,217.76</b>	<b>3,770,074,344.34</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,242,756,217.76	3,770,074,344.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	646,474,947.42	646,474,947.42
51101	Өмч: - төрийн	646,474,947.42	646,474,947.42
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,273,434,771.82	2,773,206,898.40
51210	Өмнөх үеийн үр дүн	2,273,434,771.82	2,273,434,771.82
51220	Тайлант үеийн үр дүн	-	527,318,126.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	322,846,498.52	322,846,498.52
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,248,210,057.46</b>	<b>3,775,945,269.70</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,675,585,146.18</b>	3,282,530,597.76
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,129,227,106.18</b>	376,482,261.76
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,129,227,106.18	376,482,261.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,129,227,106.18	376,482,261.76
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -ҮХ	1,128,627,106.18	305,703,261.76
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	-	70,779,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,546,358,040.00</b>	<b>2,906,048,336.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	66,860,240.00	56,242,411.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,098,217.00	40,229,837.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,762,023.00	16,012,574.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	2,479,497,800.00	2,849,805,925.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,479,497,800.00	2,849,805,925.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,179,730,004.76</b>	<b>2,755,212,471.18</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,179,730,004.76</b>	<b>2,755,212,471.18</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,782,916,238.93	2,136,710,248.29
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	682,299,556.65	731,195,429.17
210101	Үндсэн цалин	371,850,179.65	392,014,586.59
210102	Нэмэгдэл	231,958,694.00	260,643,952.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,360,000.00	33,040,000.00
210104	Урамшуулал	17,303,900.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	12,826,783.00	45,496,890.34
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	86,093,463.09	92,983,556.22
210201	Тэтгэврийн даатгал	58,657,960.00	63,573,940.54
210202	Тэтгэмжийн даатгал	6,806,596.36	7,391,305.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,617,647.08	3,642,193.09
210204	Ажилгүйдлийн даатгал	3,369,898.42	3,642,193.09
210205	Эрүүл мэндийн даатгал	13,641,361.23	14,733,923.67
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	104,414,339.68	185,416,545.40
210301	Гэрэл, цахилгаан	13,561,790.88	23,985,579.00
210302	Түлш, халаалт	90,852,548.80	161,211,966.40
210303	Цэвэр, бохир ус	-	219,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	43,490,900.00	48,619,845.00
210401	Бичиг хэрэг	7,528,800.00	4,787,700.00
210402	Тээвэр, шатахуун	29,081,600.00	33,309,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,127,000.00	2,857,525.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	310,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,810,500.00	1,019,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,633,000.00	6,525,900.00
2105	<b>Нормативт зардал</b>	12,000.00	2,105,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,000.00	-
210502	Хоол, хүнс	-	927,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,178,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	44,396,041.00	110,729,697.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,240,000.00	9,796,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	13,128,192.00
210604	Урсгал засвар	34,156,041.00	87,805,005.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	26,188,000.00	27,832,000.00

210702	Дотоод албан томилолт	26,188,000.00	27,832,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>457,331,828.00</b>	<b>533,691,965.15</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	454,581,150.00	531,661,871.15
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	523,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	723,666.00	475,748.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	322,412.00	426,396.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,600.00	-
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	338,690,110.51	404,135,710.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,674,855.00	85,899,778.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	673,200.00	1,580,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	232,342,055.51	316,655,932.35
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	396,813,765.83	618,502,222.89
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	64,242,786.00	33,253,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	24,090,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,201,122.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,081,664.00	7,278,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,960,000.00	1,885,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	332,570,979.83	583,770,980.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	332,570,979.83	583,770,980.89
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	1,478,242.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,478,242.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,495,855,141.42</b>	<b>527,318,126.58</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,495,855,141.42</b>	<b>527,318,126.58</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,240,950,640.00</u></b>	<b><u>2,914,924,913.00</u></b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>600,000.00</b>	-
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	600,000.00	-
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	600,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,240,350,640.00</b>	<b>2,914,924,913.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	92,554,240.00	65,118,988.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,098,217.00	40,229,837.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,456,023.00	24,889,151.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	2,147,796,400.00	2,849,805,925.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,147,796,400.00	2,849,805,925.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,103,260,240.00</u></b>	<b><u>2,546,029,873.00</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,103,260,240.00</b>	<b>2,546,029,873.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,696,984,667.17</b>	<b>1,919,054,604.11</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	682,358,218.27	726,052,478.85
210101	Үндсэн цалин	377,303,582.27	383,690,956.27
210102	Нэмэгдэл	228,166,389.00	266,048,341.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,927,764.00	31,814,318.00
210104	Урамшуулал	17,262,500.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	12,697,983.00	44,498,863.34
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	86,089,841.92	92,521,109.45
210201	Тэтгэврийн даатгал	59,979,984.61	63,217,020.17
210202	Тэтгэмжийн даатгал	6,832,996.36	7,353,158.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,560,997.08	3,623,375.29
210204	Ажилгүйдлийн даатгал	3,369,898.42	3,623,375.29
210205	Эрүүл мэндийн даатгал	12,345,965.45	14,704,180.47
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	97,134,499.98	188,394,385.10
210301	Гэрэл, цахилгаан	13,561,790.88	23,985,579.00
210302	Түлш, халаалт	83,572,709.10	164,125,806.10
210303	Цэвэр, бохир ус	-	283,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,928,200.00	32,905,445.00
210401	Бичиг хэрэг	4,836,000.00	2,813,300.00
210402	Тээвэр, шатахуун	24,978,200.00	23,984,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,127,000.00	2,610,025.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,867,000.00	3,377,500.00
2105	<b>Нормативт зардал</b>	-	2,864,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,864,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	61,171,941.00	154,166,484.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,316,900.00	40,862,287.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	13,128,192.00
210604	Урсгал засвар	38,855,041.00	100,176,005.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	23,808,000.00	30,212,000.00
210702	Дотоод албан томилолт	23,808,000.00	30,212,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	606,358,967.00	588,284,256.21

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	603,608,289.00	586,254,162.21
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	523,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	723,666.00	475,748.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	322,412.00	426,396.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,600.00	-
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	106,134,999.00	103,654,445.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,292,799.00	102,899,445.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,842,200.00	755,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>406,275,572.83</b>	<b>626,975,268.89</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	64,282,786.00	33,253,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	24,090,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,201,122.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,081,664.00	7,278,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	1,885,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	332,570,979.83	583,770,980.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	332,570,979.83	583,770,980.89
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	9,421,807.00	9,951,288.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,421,807.00	9,951,288.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>137,690,400.00</u></b>	<b><u>368,895,040.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>137,700,000.00</b>	<b>368,895,040.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>137,700,000.00</b>	<b>368,895,040.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	137,700,000.00	368,895,040.00
223001	Бусад хөрөнгө	137,700,000.00	368,895,040.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(137,700,000.00)</u></b>	<b><u>(368,895,040.00)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-
24	<b>ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР</b>	-	-
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(9,600.00)	-
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	9,600.00	-
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>646,474,947.42</b>	<b>322,846,498.52</b>	<b>2,273,434,771.82</b>	<b>3,242,756,217.76</b>
<b>C02</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>C03</b>	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	646,474,947.42	322,846,498.52	2,273,434,771.82	3,242,756,217.76
<b>C04</b>	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
<b>C05</b>	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
<b>C06</b>	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
<b>C07</b>	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
<b>C08</b>	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>646,474,947.42</b>	<b>322,846,498.52</b>	<b>2,273,434,771.82</b>	<b>3,242,756,217.76</b>
<b>D01</b>	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>646,474,947.42</b>	<b>322,846,498.52</b>	<b>2,273,434,771.82</b>	<b>3,242,756,217.76</b>
<b>D02</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>D03</b>	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	646,474,947.42	322,846,498.52	2,273,434,771.82	3,242,756,217.76
<b>D04</b>	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
<b>D05</b>	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
<b>D06</b>	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
<b>D07</b>	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
<b>D08</b>	Тайлант үеийн үр дүн	-	-	527,318,126.58	527,318,126.58
<b>D09</b>	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>646,474,947.42</b>	<b>322,846,498.52</b>	<b>2,800,752,898.40</b>	<b>3,770,074,344.34</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,824,613,400.00</b>	<b>2,266,034,944.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,314,113,400.00</b>	<b>1,897,139,904.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,276,709,200.00</b>	<b>1,863,886,904.11</b>
<b>2101</b>	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	870,000,000.00	726,052,478.85
<b>210101</b>	Үндсэн цалин	355,833,600.00	383,690,956.27
<b>210102</b>	Нэмэгдэл	392,726,400.00	266,048,341.24
<b>210103</b>	Унаа хоолны хөнгөлөлт	55,440,000.00	31,814,318.00
<b>210105</b>	Гэрээт ажлын хөлс	66,000,000.00	44,498,863.34
<b>2102</b>	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,750,000.00	92,521,109.45
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	73,950,000.00	63,217,020.17
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	8,700,000.00	7,353,158.23
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	4,350,000.00	3,623,375.29
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	4,350,000.00	3,623,375.29
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	17,400,000.00	14,704,180.47
<b>2103</b>	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	208,209,000.00	188,394,385.10
<b>210301</b>	Гэрэл, цахилгаан	25,000,100.00	23,985,579.00
<b>210302</b>	Түлш, халаалт	181,408,900.00	164,125,806.10
<b>210303</b>	Цэвэр, бохир ус	1,800,000.00	283,000.00
<b>2104</b>	Хангамж, бараа материалын зардал	44,523,200.00	32,905,445.00
<b>210401</b>	Бичиг хэрэг	5,000,000.00	2,813,300.00
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	30,000,000.00	23,984,620.00
<b>210403</b>	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,478,200.00	2,610,025.00
<b>210405</b>	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,045,000.00	120,000.00
<b>210406</b>	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	3,377,500.00
<b>2105</b>	Нормативт зардал	5,000,000.00	2,864,000.00
<b>210503</b>	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	2,864,000.00
<b>2106</b>	Эд хогшил, урсгал засварын зардал	170,185,200.00	134,166,484.50
<b>210601</b>	Багаж, техник, хэрэгсэл	63,685,200.00	40,862,287.50
<b>210603</b>	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,000,000.00	13,128,192.00
<b>210604</b>	Урсгал засвар	91,500,000.00	80,176,005.00
<b>2107</b>	Томилолт, зочны зардал	33,000,000.00	30,212,000.00
<b>210702</b>	Дотоод албан томилолт	33,000,000.00	30,212,000.00
<b>2108</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	703,944,000.00	567,036,256.21
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	699,821,000.00	565,006,162.21
<b>210802</b>	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	622,800.00	-
<b>210803</b>	Даатгалын үйлчилгээ	1,014,300.00	523,950.00
<b>210804</b>	Тээврийн хэрэгслийн татвар	536,400.00	475,748.00
<b>210805</b>	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,600.00	154,000.00
<b>210806</b>	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740,400.00	450,000.00
<b>210807</b>	Газрын төлбөр	963,500.00	426,396.00
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	133,097,800.00	89,734,745.00
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	131,548,900.00	88,979,745.00
<b>210902</b>	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,548,900.00	755,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>37,404,200.00</b>	<b>33,253,000.00</b>
<b>2132</b>	Бусад урсгал шилжүүлэг	37,404,200.00	33,253,000.00
<b>213205</b>	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,090,000.00	24,090,000.00
<b>213208</b>	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,314,200.00	7,278,000.00
<b>213209</b>	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	1,885,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>510,500,000.00</b>	<b>368,895,040.00</b>
<b>2200</b>	Дотоод эх үүсвэрээр	510,500,000.00	368,895,040.00
<b>223001</b>	Бусад хөрөнгө	510,500,000.00	368,895,040.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,824,613,400.00</b>	<b>2,266,034,944.11</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,824,613,400.00</b>	<b>2,266,034,944.11</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>65,118,988.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>55,167,700.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	55,167,700.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	20,000,000.00
<b>210604</b>	Урсгал засвар	20,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,248,000.00
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,248,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,919,700.00
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	13,919,700.00
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9,951,288.00</b>
<b>213503</b>	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	9,951,288.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>65,118,988.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	65,118,988.00
<b>131104</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,229,837.00
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,889,151.00

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 85,444.6 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийв. Үүнд:

1. Цалингийн зардлын бүртгэлийг аккурель сууриар хөтлөөгүйгээс цалингаас суутгасан 5,444.6 мянган төгрөгийн ХХОАТ-ыг төсөвт төлөөгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй орхигдуулсан байна;
2. ОНХО-аар хийгдсэн 80,000.0 мянган төгрөгийн дулааны шугам сүлжээг үндсэн хөрөнгөд орлогоор бүртгээгүй зардалд хаасан алдааг залруулав.

Аудитаар нийт 64,179.6 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 11,220.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 52,959.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

#### **3.1 Төлбөрийн акт:**

1. Сумын засаг даргын орлогчоор ажиллаж байсан Н.Шажинбатад сонгуулийн үр дүнгээр албан тушаалаасаа чөлөөлөгдсний нэг удаагийн тэтгэмжид 11,220.0 мянган төгрөгийг үндэслэлгүй олгож төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулсан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

#### **3.2 Албан шаардлага:**

1. Олон нийтийн цагдаагийн ажилтанд үндсэн үйл ажиллагааны бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 5,050.2 мянган төгрөгийн урамшуулал олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.
2. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 арга хэмжээнд 47,909.3 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон боловч одоо хүртэл хэрэгжээгүй байна. Уг ажлыг 2025 онд гүйцэтгэхээр төлөвлөж сумын ИТХ-аар батлуулсан боловч хэрэгжүүлээгүй, гэрээг дүгнээгүй, гүйцэтгэлд хяналт тавьж арга хэмжээ авч ажиллаагүй, санхүүжилтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж баримтжуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардал	1	5,444.6	1	5,444.6								
ҮХ-ийг орлогор бүртгээгүй	1	80,000.0			1	80,000.0						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>85,444.6</b>	<b>1</b>	<b>5,444.6</b>	<b>1</b>	<b>80,000.0</b>						

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль тогтоомжийн хэрэгжилт	2	59,129.3	1	11,220.0	1	47,909.3						
Төсвийн зориулалт бус зарцуулсан	1	5,050.2			1	5,050.20						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>64,179.5</b>	<b>1</b>	<b>11,220.0</b>	<b>2</b>	<b>52,959.5</b>						

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Зөрчилгүй	0	0						
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Зөрчилгүй								



ХЭНГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23

Дугаар 53-А 2370449

Чингис хот

ХЭА-2026/181/НА-СТА-ТШС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 арга хэмжээнд 47,909.3 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон боловч одоо хүртэл хэрэгжүүлээгүй байна. Уг ажлыг 2025 онд гүйцэтгэхээр төлөвлөж сумын ИТХ-аар батлуулсан боловч хэрэгжүүлээгүй, гэрээг дүгнээгүй, гүйцэтгэлд хяналт тавьж арга хэмжээ авч ажиллаагүй, санхүүжилтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж баримтжуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг дүгнэдэггүй, он дамжсан авлага үүсгэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бүдханд-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Х.ЕРКЕГҮЛ

Монгол улс, Чингис хот, 4-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, 70562112

  
**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ**

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 17-А 2370449

Чингис хот

ХЭА-2026/181/НА-СТА-ТШС

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Батширээт сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын засаг даргын орлогчоор ажиллаж байсан Н.Шажинбатад сонгуулийн үр дүнгээр албан тушаалаасаа чөлөөлөгдсөний нэг удаагийн тэтгэмжид 11,220,000.00 /Арван нэгэн сая хоёр зуун хорин мянга/ төгрөгийг үндэслэлгүй олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хууль зөрчин олгосон нэг удаагийн тэтгэмжийн 11,220,000.00 /Арван нэгэн сая хоёр зуун хорин мянга/ төгрөгийг үндэслэлгүй шийдвэр гаргасан сумын засаг дарга Б.Алтангэрэлээр төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бүдханд-д хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Х.ЕРКЕГҮЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23

Дугаар 46-А2370449

Чингис хот

ХЭА-2026/181/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас олон нийтийн цагдаагийн ажилтанд 5,050,200.00 (таван сая тавин мянга хоёр зуун/ төгрөгийн урамшуулал олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бүдханд-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Х.ЕРКЕГҮЛ